

Англи хэлийг нэмэлт хэл болгон сурч буй сурагчдын сурлагын тайлан (K-10)

Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл

Хүндэт эцэг эх асран хамгаалагч танаа,

Хичээлийн жил бүр сургуулиас та хүүхдийнхээ сурлагын тайланг хоёр удаа хүлээн авах болно. Уг тайлан нь таны хүүхдийн сурлагын ахиц дэвшил хэр байгааг, мөн сургууль таны хүүхдийн суралцах үйл явцад хэрхэн дэмжлэг тусалцаа үзүүлж байгааг мэдэхэд тань туслах болно. Тайланд таны хүүхдийн сурлагын амжилтыг хичээл бүрээр тусгасан байна.

Англи хэлийг нэмэлт хэл болгон сурч буй сурагчдын сурлагын тайлан (English as an additional language or dialect (EAL/D))

Хэрэв таны хүүхэд англи хэлийг нэмэлт хэл (EAL/D) болгон сурч байгаа бол тайланд таны хүүхэд англи хэл сурахад ямар дэмжлэг тусалцаа үзүүлж байгаа, мөн хүүхдийн англи хэл сурах явц хэр сайн байгаа талаар тайлбарлах болно. 1-р анги болон түүнээс дээш ангийн сурагчдын хувьд уг тайланд англи хэлний мэдлэгийн аль шатанд байгааг нь давхар оруулна. Эдгээр шат нь эхлэн суралцаж буй, шинээр эзэмшиж буй, хөгжүүлж буй, бататгаж буй гэсэн түвшнүүдтэй. Дараагийн хуудсанд буй шат тус бүрийн тодорхойлолтыг харна уу.

Шинээр ирсэн (EAL/D) сурагчдын сурлагын тайлан

Хэрэв таны хүүхэд EAL/D хөтөлбөрт хамрагдаж, Австралийн сургуульд дөрвөн улирал эсвэл түүнээс бага хугацаанд суралцсан бол тайланд хичээлийн дүнгийн оронд сурагчийн суралцаж буй хичээлүүддээ гаргаж буй ахиц дэвшлийн талаарх мэдээлэл агуулсан байж болно.

Эрчимжүүлсэн англи хэлний төв болон Эрчимжүүлсэн англи хэлний ахлах сургуульд шинээр элссэн EAL/D сурагчдын сурлагын тайлан

Хэрэв таны хүүхэд Эрчимжүүлсэн англи хэлний төвд, эсвэл Эрчимжүүлсэн англи хэлний ахлах сургуульд сурч байгаа бол сурагчын англи хэлний хичээлд гаргаж буй ахицыг харуулсан сурлагын тайланг хүлээн авна. Үүнээс гадна ахлах сургуульд бэлтгэх зорилгоор судалж буй бүх хичээлийн ахиц дэвшлийг уг тайланд тусгах болно.

Англи хэлний мэдлэгийн шат түвшингүүд

Эхлэн суралцаж буй түвшин	Энэ түвшинд байгаа сурагчид англи хэлийг шинээр суралцаж эхэлж байна. Тэд нэг буюу хэд хэдэн өөр хэлээр ярьж чаддаг бөгөөд төрөлх хэл дээрээ насандаа тохирсон бичгийн чадвартай болсон байж болно. Эдгээр сурагчид сургалтын хөтөлбөрийн дагуу англи хэлний энгийн дасгал хичээл хийж эхэлж буй сурагчид юм.
Шинээр эзэмшиж буй түвшин	Энэ шатанд сурагчдын англи хэлний мэдлэг өсөн нэмэгдэж байдаг. Тэд нэг буюу хэд хэдэн хэлээр ярьж чаддаг бөгөөд англи хэлний анхан шатны мэдлэгтэй болж бичгийн англи хэлний мэдлэгээ нэмэгдүүлж байна. Зөв зохистой хэлний сургалт болон нэмэлт цагаар сургавал тэд хичээлийн явцад оролцож, сурах явцдаа амжилт гаргах боломжтой.
Хөгжүүлж буй түвшин	Энэ шатанд сурагчид нэг буюу хэд хэдэн хэлээр, түүний дотор өдөр тутмын хэрэглээний англи хэлээр ярьж чаддаг бөгөөд бичгийн англи хэлний мэдлэгээ хөгжүүлж байна. Тэд ангидаа мөн сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог ба аливаа хичээл даалгаврыг улам бүр амжилттай биелүүлж чаддаг. Тэдний эх хэл нь англи хэлний дүрмийг эзэмших, үгийн сангаа өргөжүүлэхэд чухал дэмжлэг болсон хэвээр байна.
Бататгаж буй түвшин	Энэ шатанд сурагчид нэг буюу хэд хэдэн хэлээр, түүний дотор англи хэлээр ярьж чаддаг бөгөөд бичгийн англи хэлний сайн мэдлэгтэй байдаг. Тэд ангид болон сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаанд бие даан оролцож, англи хэлийг ашиглан шинийг суралцах явцдаа англи хэлийг амжилттай ашиглах чадвартай болсон байна. Тэд төрөл бүрийн сэдвээр ярианы болон бичгийн эхийг ойлгож, бүтээж чаддаг боловч хичээлийн академик хэлний түвшин нэмэгдэх тул EAL/D сурагчдад зориулсан тусгай хэлний сургалт, дэмжлэг хэрэгтэй хэвээр байна.

Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрэв та нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл сургуультай холбогдоно уу. Сургуультай холбогдоход тань орчуулагчийн туслалцаа хэрэгтэй бол 131 450 дугаараар Утсан орчуулагчийн үйлчилгээтэй холбогдож өөрийн хэл дээрх орчуулагчийг хүснэ үү. Орчуулагч нь сургуультай холбогдож, таныг сургуулийн ажилтантай ярилцахад тань туслана. Энэхүү үйлчилгээ нь үнэ төлбөргүй болно.